

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан
шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

Байгууллагын нэр:

Баян-Өлгий аймгийн Байгаль орчин,
аялал жуулчлалын газар

Албан тушаалын нэр:

Байгаль хамгаалагч

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Нэгжийн нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Туслах түшмэл, ТЗ-2

Ажлын байрны албан ёсны байршил:

Баян-Өлгий аймаг, Өлгий сум, Ховд гол баг.

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгалийн нөөц баялгийг хариуцан хамгаалах, зүй зохистой ашиглуулах, нөхөн сэргээх, орчны бохирдлыг бууруулах, байгаль орчны боловсролыг түгээн дэлгэрүүлж иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1.Хариуцсан нутаг дэвсгэртээ байгалийн нөөц баялгийг хариуцан хамгаалах, нөхөн сэргээх, байгаль орчны бохирдолд дүн шинжилгээ хийх, бохирдлыг бууруулах, учирч болзошгүй хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх талаар төрийн бодлого шийдвэр, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, тайлагнах.

2.Байгаль орчны ажиглалт судалгаа хийх, байгаль хамгаалах төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, байгаль орчны боловсролыг түгээн дэлгэрүүлж иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх.

3.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Салбарын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, байгаль орчинд учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, байгалийн баялгийг хамгаалах;	Байгалийн баялгийг зөв зохистой ашиглах, хамгаалах, хамгааллын механизм бүрдсэн байна.	Г, Х
	2.Ой, ус, ургамал, амьтан, газар, газрын хэвлий, түүний баялгийн ашиглалтад иргэд, төрийн бус байгууллагын оролцоотой хяналт тавих, холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэх, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх;		Г, Х
	3.Байгалийн баялаг ашиглах газрыг тогтоох, зөвшөөрөл олгох, гэрээ байгуулах, төлбөр ногдуулалт хийж хэрэгжилтийг нь хангуулж хяналт тавих;		Г, Х
	4.Биологи, түүх, соёл, палеонтологи, геологийн хувьд ач холбогдол бүхий газруудыг тогтоож, орон нутгийн тусгай хамгаалалтад авах, хамгаалах арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх, тайлагнах;		Г
	5.Байгалийн баялгийг нөхөн сэргээх, биологийн төрөл зүйлийн амьдрах орчныг сайжруулах, иргэд, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх;		Г



	6.Агаарын бохирдол, хог хаягдал, химийн бодисын ашиглалтын үйл ажиллагааны улмаас байгаль орчинд үзүүлж буй бохирдлыг бууруулах арга хэмжээг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, шийдвэрлүүлэх.		Г, Х
2 дугаар зорилтын хүрээнд	1.Байгаль орчинд гарч буй өөрчлөлтийг ажиглах, судалгаа хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, холбогдох арга хэмжээг цаг алдалгүй авахуулж, мэдээллийн санд оруулах;	Судалгаа, шинжилгээний ажлууд хийгдэж мэдээллийн сан үүссэн байна.	Г
	2.Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа байгаль хамгаалах чиглэлийн төрийн бус байгууллага, нөхөрлөл, клуб, идэвхтэн байгаль хамгаалагчтай хамтран ажиллах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, урамшуулах;	Орон нутагт ажиллаж байгаа төрийн бус байгууллагатай хамтын ажиллагаа сайжирсан байна.	Г
	3.Байгаль орчны боловсролыг түгээн дэлгэрүүлэх, сургалт арга хэмжээг зохион байгуулах;	Иргэдийн мэдлэг мэдээлэл дээшилсэн байна.	Г
	4.Аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх, орон нутгийн онцлогийг илэрхийлсэн брэнд бүтээгдэхүүн, эвент арга хэмжээг тодорхойлох, сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулах;	Орон нутгийн онцлогийг илтгэсэн брэнд, эвент арга хэмжээтэй болсон байна.	Г
	5.Аялал жуулчлалын статистик судалгаа гаргах, мэдээллийн сан бий болгох.	Статистик тоо мэдээ жил бүр шинэчилэгдсэн байна.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.Төрийн албаны тухай хууль, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг чанд баримталж, хууль тогтоомжоор олгогдсон эрх, үүргээ шударгаар хэрэгжүүлэх;	Орон нутгийн онцлогийг илтгэсэн брэнд, эвент арга хэмжээтэй болсон байна.	Г
	2.Хүнд суртал, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, төрийн үйлчилгээг соёлтой, шуурхай хүргэх;	Статистик тоо мэдээ жил бүр шинэчлэгдсэн байна.	Г



3.Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;	Журам, заавар, стандартыг мөрдөн ажилласан байна.	Г
4.Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулж, мэдлэг мэргэшлээ дээшлүүлэх;	Гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан байна.	Г
5.Удирдлагын хуульд нийцсэн үүрэг даалгаврыг шуурхай биелүүлэх, эргэн мэдээлэх;	Удирдлагыг мэдээллээр хангаж ажилласан байна.	Г
6.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.	Чиг үүргийг хэрэгжүүлсэн байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бүрэн дунд ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх. бакалавр зэрэгтэй бол давуу тал болно.	
Мэргэжил	Мэргэжил шаардахгүй.	
Мэргэшил	Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр мэргэшсэн бол давуу тал болно.	
Туршлага	Идэвхтэн байгаль хамгаалагчаар чиглэлээр мэргэшсэн бол давуу тал болно.	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- байгууллагын чиг үүргийн хэрэгжилтэд өөрийн ажил үүргийн оруулах хувь нэмэр, оролцоог ойлгодог - өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг.
	Асуудал шийдвэрлэх	- үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж төрд үнэнчээр зүтгэх; - албан үүргээ ёс зүйн зарчимд нийцүүлэн, ашиг сонирхлын зөрчлөөс ангид шийдвэрлэх; - байгууллагын чиг үүргийн хэрэгжилтэд өөрийн ажил үүргийн оруулах хувь нэмэр, оролцоог ойлгодог - өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг - иргэдийн санал бодлыг сонсох бодлыг сонсох зөв хандлагыг дэмжих, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах
	Багаар ажиллах	- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, хамтран ажиллах; - багийн хүрээнд өөрт ногдсон үүргээ гүйцэтгэх.



Бусад	<ul style="list-style-type: none"> - өргөн цар хүрээтэй сэтгэж, үлгэрлэн манлайлдаг байх, - зарчимч, тууштай, ажил хэрэгч байх; - шинэ санал, санаачилга, бүтээлч хандлагатай байх; - хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай байх.
-------	---

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

- Байхгүй.

Бусад харилцах субъект :

- Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газрын холбогдох албан тушаалтан
- Байгаль орчин, аялал жуулчлалын газрын холбогдох албан тушаалтан
- Сумдын болон багийн Засаг дарга
- Төрийн болон төрийн бус байгууллага
- Иргэн, хуулийн этгээд.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

ХҮНИЙ НӨӨЦ, УУЛ УУРХАЙ, БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН.....С. МАНДАТ

2019 оны 12 дугаар сарын 26-ны өдөр

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо **19 11 04**.....

292
Дугаар

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

Баян-өлгий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар

Шийдвэрийн огноо **2019-12-26**.....

Дугаар **170**.....

(тамга/тэмдэг)

ДАРГА Ш.МАРАТ

2019 оны 12 дугаар сарын 26-ны өдөр

